

ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

Агуулга:

1. Нийтлэг үндэслэл
2. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч элсүүлэх
3. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн агуулга, үнэлгээ
4. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн Мэргэжлийн багш нарын зөвлөл, түүний эрх, үүрэг
5. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагчийн эрх, үүрэг
6. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага
7. Журам хүчин төгөлдөр болох

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль /цаашид “МГТИС” гэх/-ийн Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн зорилго, сургалтын агуулга, суралцагчдын мэдлэг, чадвар, дадлын үнэлгээ болон суралцагчдын эрх, үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Инженерийн бэлтгэл хөтөлбөр нь бакалаврын хөтөлбөрт дэвшин суралцах сургалтын үндсэн хэсэг болно.
- 1.3. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн зорилго нь суралцагчдыг МГТИС-ийн бакалаврын хөтөлбөрт дэвшин суралцахад бэлтгэхэд чиглэгдэнэ. Уг хөтөлбөрт математик, физик, хими, компьютерийн мэдээлэл зүй зэрэг инженерийн ухааны суурь хичээлүүд, англи хэлний хичээл багтана. Мөн түүнчлэн үйлдвэрлэлийн ба лабораторийн дадлага болон чадвар олгох сургалт явуулна.
- 1.4. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой зарчмын шийдвэрүүдийг Эрдмийн зөвлөл гаргана.
- 1.5. Энэхүү журмыг МГТИС-ийн багш нар, Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн нийт оюутан чанд дагаж мөрдөнө.
- 1.6. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Факультетийн зөвлөл мөн Мэргэжлийн багш нарын зөвлөл гаргах бөгөөд МГТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
- 1.7. Журам нь МГТИС-ийн бусад дүрэм, журамтай харилцан уялдаж мөрдөгдөнө.
- 1.8. Журам нь Инженерийн бэлтгэл хөтөлбөр хэрэгжих хичээлийн жилийн туршид үйлчилнэ.

2. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч элсүүлэх

- 2.1. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл, элсэлт нь “МГТИС-ийн оюутан элсүүлэх журам”-аар зохицуулагдана.
- 2.2. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь “МГТИС-д оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэн орж, МГТИС-тай ‘Оюутан суралцуулах гэрээ’ хийсэн байх шаардлагатай.

- 2.3. Элсэгч нь Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн хоёрдугаар улиралд шууд элсэн суралцаж болно. Энэ тохиолдолд элсэгч нь “МГТИС-ийн оюутан элсүүлэх журам”-ын зохих шаардлагыг хангасан байх бөгөөд нэгдүгээр улиралд үзсэн хичээлүүдийн агуулгын дагуу элсэлтийн шалгалт өгч тэнцсэн байна.
- 2.4. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт шууд элсэн суралцах эрх олгогдохгүй.

3. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн агуулга, үнэлгээ

- 3.1. Инженерийн бэлтгэл хөтөлбөр нь дараах модультай байна. Модулийн цагийн бүтэц Журмын хавсралт -1-д заасны дагуу байна.
 - A. Үндсэн хичээл:
 - Математик (долоо хоногт 8 цаг)
 - Физик (долоо хоногт 6 цаг)
 - Хими (долоо хоногт 4 цаг)
 - Компьютерийн хэрэглээ (долоо хоногт 4 цаг (2-р семестрт))
 - Англи хэл (долоо хоногт 8-15 цаг)
 - Герман хэл (C1 шатаа дүүргэсэн бол сонгох боломжтой)
 - B. Чадвар олгох сургалт:
 - Арга барилын чадвар: танилцуулга хийх ур чадвар, ажлын зохион байгуулалт, судалгаа хийх чадвар, үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа, төслийн менежмент (Нийт 32 цаг)
 - Нийгмийн чадвар: багаар ажиллах чадвар, олон соёлын чадамж, удирдах арга барил, илтгэх ба хөтлөх чадвар (Нийт 32 цаг)
- 3.2. Хичээлийн нэг цагийг 45 минутаар тооцно.
- 3.3. Инженерийн бэлтгэл хөтөлбөр нь нэг жилийн хугацаатай. Нэг улирал нь 16 долоо хоногтой байна. Шалгалтын болон үйлдвэрлэлийн дадлагын хугацааг хичээлийн жилийн хуанлид тусгана.
- 3.4. Сургалтыг хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулна.
- 3.5. Хичээлийн ирцийг бүртгэнэ. Суралцагчийн хичээлийн ирц 80 хувиас доошгүй бол тухайн улирлын эцсийн шалгалтад орох эрхтэй. Хэрвээ ирц 80 хувиас доош тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааныг (өвчний учир буюу бусад хүндэтгэн үзэх шалтгаан) Мэргэжлийн багш нарын зөвлөлийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шалгалтад орох эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.6. Суралцагчийн хөтөлбөрийн хугацаанд эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлыг улирал бүрт үндсэн хичээл тус бүрт 100 оноогоор үнэлж дүгнэнэ. Тухайн хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд хангалттай гэж үзнэ.
- 3.7. Үндсэн хичээл тус бүрийн улирлын нийт үнэлгээ нь явцын үнэлгээ болон улирлын эцсийн шалгалтын онооноос бүрдэнэ. Явцын үнэлгээ нь улирлын нийт үнэлгээний 30%, шалгалтын оноо нь улирлын нийт үнэлгээний 70% байна.

- 3.8. Суралцагч нэгдүгээр улиралд үндсэн хичээл бүрт хангалттай үнэлгээ авч тэнцсэн тохиодолд хоёрдугаар улиралд үргэлжлүүлэн суралцаж болно.
- 3.9. Суралцагч нэгдүгээр улиралд үндсэн хичээлүүдийн аль нэгд тэнцээгүй бол анхааруулга авах ба тухайн хичээлийн давтан шалгалтыг 5-р сарын хоёр дахь долоо хоногт өгч болно.
- 3.10. Суралцагч хоёрдугаар улиралд үндсэн хичээлүүдийн аль нэгд тэнцээгүй бол тухайн хичээлийн давтан шалгалтыг дараагийн хичээлийн жилийн эхэнд өгнө.
- 3.11. Суралцагч нь давтан шалгалтын дараа нэгдүгээр улиралд заасан үндсэн хичээлүүдийн аль нэгд хангалттай үнэлгээ авч чадаагүй бол дараагийн хичээлийн жилд инженерийн бэлтгэл хөтөлбөрт давтан суралцах эрхтэй.
- 3.12. Суралцагч хоёрдугаар улирлын үндсэн хичээлүүдийн аль нэгд хангалттай үнэлгээ авч чадаагүй бол дараагийн хичээлийн жилийн хоёрдугаар улиралд давтан суралцах эрхтэй. Суралцагч өөрийн хүсэлтээр, зохих сургалтын төлбөрийг төлж инженерийн бэлтгэл хөтөлбөрийн нэгдүгээр улиралд давтан суралцаж болно. Хүсэлтийг Сургалтын Албанд бичгээр гаргаж, Мэргэжлийн багш нарын зөвлөлөөр шийдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд өмнөх хичээлийн жилийн нэгдүгээр улирлын үнэлгээг хүчингүйд тооцно.
- 3.13. Суралцагч 2 улиралд үндсэн хичээл бүрт хангалттай үнэлгээ авч, амжилттай суралцсан тохиолдолд МГТИС-ийн бакалаврын хөтөлбөрт дэвшин суралцах болзол хангана.
- 3.14. Суралцагч нэг улиралд нэг удаа давтан сурч болно.

4. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн Мэргэжлийн багш нарын зөвлөл, түүний эрх, үүрэг

- 4.1. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт багшилж байгаа багш нар Мэргэжлийн багш нарын зөвлөлийг бүрдүүлнэ.
- 4.2. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн багш нар Мэргэжлийн багш нарын зөвлөлийн зөвлөгөөнд оролцох үүрэгтэй.
- 4.3. Мэргэжлийн багш нарын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 4.4. Мэргэжлийн багш нарын зөвлөл нь модуль бүрийн тодорхойлолтыг хичээлийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн Эрдмийн зөвлөлөөр батлуулна.
- 4.5. Мэргэжлийн багш нарын зөвлөл нь сургалтын ажлын онол, арга зүйн ерөнхий чиг үүрэг, зорилгыг хэлэлцэн тогтооно.
- 4.6. Уг зөвлөл нь оюутнуудыг шалгалтанд оруулах, анги дэвшүүлэх, анги алгасуулан суралцуулах, эсвэл давтан суралцуулах, сургуулиас хасах, чөлөөлөх асуудлыг хэлэлцэн, саналаа захиралд хүргүүлнэ.

5. Тав. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагчийн эрх, үүрэг

- 5.1. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь “МГТИС-ийн Элсэлтийн журам”-ын дагуу элсэн орж, “Оюутан суралцуулах гэрээ” байгуулснаар тус сургуульд бүртгэлтэй оюутан болно.
- 5.2. Инженерийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь сургалтын арга хэмжээнд тогтмол оролцох, хичээлд хоцрохгүй, таслахгүй байх, амжилттай суралцах үүрэгтэй.

- 5.3. Суралцагч нь Сургуулийн дотоод дүрэм, журмууд, түүний дотор “МГТИС-ийн оюутны ёс зүйн дүрэм”-ийг чанд баримтална.
- 5.4. Суралцагч нь улирлын болон явц дундын шалгалтад заавал оролцоно. Хэрэв суралцагч улирлын болон явц дундын шалгалтын өдрүүдэд шалгалтад оролцож чадаагүй тохиолдолд дүнг хангалтгүйд тооцно. Онцгой хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд Мэргэжлийн багш нарын зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх эрхтэй.
- 5.5. Журмын 5.3-д заасан хүндэтгэн үзэх шалтгааны магадлагааг 3 –аас доошгүй хоногийн дотор Сургалтын албанд өгнө.
- 5.6. Суралцагчдын хамтын оролцоог хангах, сургуулийн дотор болон гадагшаа оюутнуудын эрх, ашиг сонирхлыг төлөөлөх МГТИС-ийн Оюутны Зөвлөлд инженерийн бэлтгэл хөтөлбөрийн суралцагсдын төлөөлөл сонгогдох эрхтэй.

6. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 6.1. Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн суралцагч журмын 5.2-т заасан үүргийг биелүүлээгүй бол тухайн оюутанд Сургалтын албанаас бичгээр сануулга өгнө.
- 6.2. Хэрэв суралцагч шалгалтын үеэр хуулах, хуулахыг оролдсон, зөвшөөрснөөс бусад материал ашигласан, шалгалтыг санаатайгаар үймүүлсэн зэрэг тохиолдолд шалгалтыг цааш үргэлжлүүлэхийг зогсоон, шалгалтыг хангалтгүй үнэлгээгээр тооцно. Маргаантай тохиолдолд мэргэжлийн багш нарын зөвлөлтэй хамтран шийдвэрлэнэ.
- 6.3. Журмын 6-д заасан үйлдлийг удаа дараа давтсан суралцагчийн МГТИС-д суралцах эрхийг цуцална.

7. Журам хүчин төгөлдөр болох

- 7.1. Энэхүү журам нь МГТИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийн энгийн олонхийн саналаар батлагдсанаар хүчин төгөлдөр болно.

*Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн
сургалтын журмын I хавсралт*

ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЦАГИЙН БҮТЭЦ

Инженерийн бэлтгэл хөтөлбөрийн нийт цагийн бүтэц					
Нэгдүгээр улирал			Хоёрдугаар улирал		
Код	Модуль хичээлийн нэр	Цаг	Код	Модуль хичээлийн нэр	Цаг
MATH-101	Математик I	96	MATH-102	Математик II	96
PHYS-101	Физик I	72	PHYS-102	Физик II	72
CHEM-101	Хими I	48	CHEM-102	Хими II	48
ENG-101	Англи хэл	224	ENG-102	Англи хэл	224
GENS-101	Ерөнхий чадавхи - Арга барилын чадвар	16	INF-101	Информатикийн үндэс	64
			GENS-101	Ерөнхий чадавхи – Нийгмийн чадвар	16
Нэгдүгээр улирлын нийт цаг		456	Хоёрдугаар улирлын нийт цаг		520